



МОНГОЛ УЛС
ДУНДГОВЬ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2019 оны 11 сарын 22 өдөр

Дугаар А/405

Мандалговь

□ Барилгын ажил эхлүүлэх, үргэлжлүүлэх, □
ашиглалтад оруулах арга хэмжээний тухай

Монгол Улсын Барилгын тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.1.1, 35.1.2 дахь заалт, 37-р зүйлийн 37.1.4 дэх заалт, Засгийн Газрын 2017 оны 6 дугаар сарын 14-ний өдрийн 170 дугаар тогтоолын 3.12 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

Нэг. Монгол улсын Засгийн газрын 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн 218 дугаар тогтоолоор батлагдсан “Барилга байгууламжийн төвөгшлийн ангиллыг зориулалт хүчин чадлаар нь тогтоох дүрэм”-д заасан бага, дунд, өндөр төвөгшлийн ангиллын барилга байгууламж, инженерийн шугам сүлжээний угсралтын ажлыг хөрөнгийн эх үүсвэр харгалзахгүйгээр барилга угсралтын ажилд захиалагчийн хяналтын гэрээ байгуулж, хяналт тавьж ажиллахыг Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар (Э.Чагнаадорж)-д үүрэг болгосугай

Хоёр. Магадлал хийгдсэн зураг төсөвгүй, захиалагчийн хяналт гүйцэтгэх болон зохиогчийн хяналт хийх гэрээ байгуулаагүй, барилгын ажил эхлүүлэх, үргэлжлүүлэх зөвшөөрөлгүй барилга байгууламжийг ашиглалтад оруулахгүй байхыг сумдын Засаг дарга нарт даалгасугай.

Гурав. Энэхүү захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Мэргэжлийн хяналтын газар (Ш.Төрбат)-т даалгасугай.

Дөрөв. Энэ захирамж гарсантай холбогдуулан аймгийн Засаг даргын 2016 оны 2 дугаар сарын 19-ний өдрийн А/57 захирамжийг хүчингүй болсонд тооцсугай.

ДАРГА



О. БАТ-ЭРДЭНЭ

488191142